

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны 11 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн	Биелэлт
1	2	3	4	5
1	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	9-11 сард	Албан хаагчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдана.	Албан хаагчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар Хавдар судлалын үндэсний төв, Төрийн албан хаагчийн эмнэлэг, Улсын Нэгдүгээр төв эмнэлэгт хүсэлт гаргаж үнийн санал мэдээллийг нэгтгэн авсан. Сайн дураараа үзлэгт 10 албан хаагч хамрагдсан.
2	Албан хаагчдад бие бялдар, гоо зүйн төлөвшил олгох соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах.	6-12 сард	Албан хаагчдын бие бялдар, гоо зүйн төлөвшил сайжирна.	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын гэр бүлийн гишүүдийг хамруулан “Гэр бүлийн өдөрлөг” сэдэвт уралдаан тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 29-нд зохион байгуулсан. Албан хаагчдыг ажлын байр дээр идэвхжүүлэх, 3 удаагийн аян зохион байгуулсан. Үүнд World tourism day, Хотын соёл-Хариуцлагатай албан хаагч, Арван нэгдүгээр сарын амжилтаар угтая зэрэг ажлуудад ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэн ажилласан.
3	Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчдад буцалтгүй тусламж, хөнгөлөлт олгох.	1-12 сард	Албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдана.	Газрын даргын 2022 оны Б/13 дугаар тушаалаар 1 албан хаагчид буцалтгүй тусламж олгосон. Байгууллагын дотоод журмын дагуу өөрийн зардлаар магистрын сургалтад хамрагдаж буй 2 албан хаагчдад цалинтай чөлөө олгон суралцуулж байна. Talk talk English сургалтын төвтэй хамтын ажиллагааны хүрээнд 2 албан хаагчийг үнэ төлбөргүй англи хэлний сургалтад хамруулсан. Койка олон улсын байгууллагаас

				зохион байгуулж буй Солонгос хэлний анхан шатны хичээлд 6 албан хаагчийг үнэ төлбөргүй сургалцуулсан.
4	Албан хаагчдын шагнал авсан судалгааг гаргаж, шагнал урамшуулалд тодорхойлох.	6-12 сард	Албан хаагчид шагнал урамшуулалд хамрагдана.	Газрын 7 албан хаагчийг шагналд тодорхойлсон. Үүнд Алтан гадас одон-3, Хөдөлмөрийн хүндэт-3, Төрийн албаны тэргүүний ажилтан-1 тус тус тодорхойлж, Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Нийслэл дэх төрийн албаны зөвлөлд материалыг хүргүүлсэн.
5	Албан хаагчдын орон сууцны нөхцөл байдлыг судалж, дэмжлэг шаардлагатай албан хаагчдын санал хүсэлтийг холбогдох байгууллагад уламжлах.	3-12 сард	Албан хаагчдын нийгмийн асуудал шийдвэрлэгдэнэ.	Газрын албан хаагчдын нийгмийн асуудлыг судлах судалгааны маягт боловсруулж 18 албан хаагчаас судалгаа авч үр дүнг нэгтгэн газрын удирдлагад танилцуулсан.
6	Албан хаагчдын хүүхдүүдийн судалгаа гаргаж, хөгжихөд дэмжлэг үзүүлэх.	2-12 сард	Албан хаагчдын хүүхдүүдийг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байна.	Албан хаагчдын хүүхдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 31 хүүхдэд бэлэг өгсөн. “Дү-Дү” хүүхдийн тоглоомын төвтэй хамтран 2022 оны 05 дугаар сарын 29-ны өдөр албан хаагчид тэдний гэр бүлийн гишүүдийн дунд 3 төрлийн тэмцээн зохион байгуулсан. Бүтэц орон тоо, бүрэлдэхүүний хөдөлгөөнөөс хамааран албан хаагчдын хүүхдийн судалгааг шинэчлэн гаргасан. Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дах заалтын хүрээнд 0-6 настай хүүхэдтэй 5 албан хаагчдад хүүхдээ хичээл сургуульд нь хүргэж өгөх ажлын цагийн зохицуулалтыг гаргасан. Хүүхдийнх нь төрсөн өдөр тохиож буй өдөр албан хаагчдад цалинтай чөлөөг дотоод журмын дагуу олгодог. Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл нь 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд чадавх бэхжүүлэх, сэтгэл зүйн сургалтад 1 гишүүнийг суулгаж чадавхжуулсан.
7	Газрын албан хаагчдын	2-5 сард	Албан хаагчид	Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв, түүний нэмэгдэл

	дэлгэрэнгүй судалгааг гаргаж зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг боловсруулан холбогдох газарт хүргүүлэх, шийдвэрлүүлэх.		зэрэг дэв, түүний нэмэгдэл авна.	олгох саналыг НЗДТГ-т хүргүүлж Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/641 дүгээр захирамжаар 4 албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулсан. 2022 оны 10 дугаар сард 2 албан хаагчийн зэрэг дэвийн олгуулах судалгааг гаргаж Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн.
--	---	--	----------------------------------	--